

БОДГАЛЬ ЕРТӨНЦИЙН ХАНДЛАГЫН ҮҮДНЭЭС ТОГТВОРТОЙ ХӨГЖИХҮЙЦ БАГШ БОЛОВСРОЛЫГ ХАРАХУЙ

Б.Жадамбаа, академич, МУБИС

Шинэчлэл өөрчлөлтийн шинэ чиг хандлага болох тогтвортой хөгжил (ТХ) загварыг үйл хэрэг болгохын үндэс нь хүмүүн бүрийн тогтвортой хөгжихүйц боловсрол (ТХБ) болохыг өнөөдөр дэлхийн хамтын нийгэмлэгийнхэн нэгэн утгатайгаар хүлээн зөвшөөрч байна. Хүмүүн бүрийн ТХБ эзэмшихүйц багш удирдан чиглүүлж, дэмжин тусалж байдаг. Удирдан чиглүүлэгч, дэмжин туслагч багш бүр өөрөө тогтвортой хөгжихүйц боловсролтой байж гэмээн шавь нар нь ТХБ-той болно. Тэгвэл тэр тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн багш бүр өөрсдөө тогтвортой хөгжихүйц боловсролтой байж л сая оюутан багшид дэмжлэг үзүүлж, бусад багш нарыг түүнд сургаж чадах төдийгүй уг ажлынхаа явцад өөрийнх нь "тогтвортой хөгжихүйц боловсрол улам улам гүнзгийрч байдаг ажээ. Эндээс, тогтвортой хөгжил загварыг үйл хэрэг болгохуйн цөм нь тогтвортой хөгжихүйц боловсролтой багш болон тогтвортой хөгжихүйц багш боловсрол (ТХББ) юм. ТХББ нь тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн мөн чанар хийгээд илрэл учраас түүнийг нэг талаас хийсвэр, нөгөө талаас, бодтой гэж үзэж болно. Иймийн учир бид өнөөгийн багш боловсролын өөрчлөлт шинэчлэлийн чиг хандлагыг ТХББ, түүний илрэлийг тогтвортой хөгжихүйц боловсролтой багш гэж ойлгож байгаа юм.

Бодгаль ертөнцийн хандлага¹ ёсоор байгаль-нийгэм-соёл-цаг хугацаа нь тогтвортой хөгжихүйц багш боловсролын хийгээд тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн нэг талаас, мөн чанар нь, нөгөө талаас, илрэл нь учраас ТХББ -ын болон тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн агуулга, хэлбэр улс үндэстэн бүрийн хувьд өөр өөр шинж төрхтэй байх ёстой. ТХББ-ын болон тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн мөн чанар буюу илрэл болох байгаль-нийгэм-соёл-цаг хугацаа нь алив орон лугаа бодот ахуй бөлгөө. Өөрөөр хэлбэл, ТХББ болон тогтвортой хөгжихүйц боловсролтой багш нь бодот ахуйн буюу байгаль- нийгэм-соёл-цаг хугацааны үзэгдэл юм. Энэ нь бидний тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийг бэлтгэх ТХББ -ын бодлого, стандарт, хөтөлбөр, аргазүйг боловсруулах,

үйл хэрэг болгох, шинжлэн үнэлэхийн үндсийг Монгол орны байгалийн, нийгмийн, соёлын тухайн цаг үеийн үйл явцын байдал, тулгамдсан асуудлууд, хөгжлийн чиг хандлага гэдгийг л хэлж өгч байна. Гэхдээ дэлхийн хэмжээнд сэтгэж, бусдаас суралцаж, бусдыг сургаж, өнөөгийнхөө байдлыг шинжлэн үнэлж, уламжлал шинэчлэлийг хослуулан, өөрийн орны орчин нөхцөлд тохируулан, бүтээлчээр хамтран ажиллахыг умартаж боломгүй юм.

ТХББ болон тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн тухай асуудлыг ухаарахын тулд бид юуны өмнө багш хүний бүтэц тогтолцоог мэдэх шаардлагатай. Мэдээж багш хүний бүтэц тогтолцоо нь ерөнхий хийсвэр чанар учраас тэр олон ургалч үзлийн үүднээс янз бүрийн загвараар илэрхийлэгдэх боломжтой. Энэ ажилд бид багш хүн, түүний хөтөч үзэл ба бүтэц тогтолцоог бодгаль ертөнцийн онолын арга талын томьёолол болох бодот ахуйн хандлагын² хүрээнд авч үзэн, түүнийхээ үндсэн дээр ТХББ болон тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн дүр төрх, түүнд тавигдах үндсэн шаардлага, тэргүүлэх чиглэл, зорилго, зорилт, шинжүүрийн бод ахуй, түүнийг судлан тогтоох аргазүй зэрэг асуудлыг шинжин тайлбарлахыг зорьсон болно.

Багш хүний талаарх бодгаль ертөнцийн хандлагын хөтөч үзэл

Багш хүний бүтэц, тогтолцооны талаарх бодгаль ертөнцийн, байгаль-нийгэм-соёл-цаг хугацааны, бодот ахуйн хандлагын хөтөч үзлийг бид:

- Багш хүн хийгээд түүний үйл хөгжил нь нэг ертөнцдөө, байгаль-нийгэм-соёл-цаг хугацаандаа, бодот ахуйдаа амьсан шингэсэн байдаг төдийгүй тэдгээрийнх лүгээ адил хууль, зүй тогтолтой, мөн чанар ба шинж чанартай
- Багш хүний оршихуйн болон хөдлөл хувирлын үндэс нь харилцахуй, харилцан үйлчлэхүй³ ба шууд хэрэгжүүлэхүй, ажил хэрэг болгохуйн нэгдэл юм,
- Харилцан үйлчлэхүйг буюу харилцахуйг

¹ Б.Жадамбаа, Суралцаж хүншихуйн талаарх бодгаль ертөнцийн хандлага, Монгол судлалын чуулган, Уб., 2010, №43

² Б.Жадамбаа, Суралцаж хүншихуйн талаарх бодгаль ертөнцийн хандлага, Уб., 2010

³ Б.Жадамбаа, Шүтэлцэн багцрахуй ба хүмүүний хөгжил, УБ, 2007

мэдээлэл⁴ буюу хэл дамжуулдаг хэмээн томъёолж болно.

Эхний хөтөч үзэл бидэнд бодот ахуй нь багш хүний мөн чанар хийгээд илрэл гэдгийг хэлж буй юм. Үүнээс бид, багш хүн болохуй, багш хүн байхуй, тэдгээрийн нэгдэл болох багш хүн, түүний үйл хөгжил нь бодот ахуйтай харилцан нөхцөлдсөн байдаг төдийгүй, бодот ахуйн үзэгдлүүд болохыг харж болно. Бодот ахуй гэдэг нь тус бүр нь өөр өөр огторгуй-хугацаа бүхий цэгүүдийн, дүрүүдийн буюу бодгаль ахуйнуудын амьсан багцрахуй, түүний үр. Уг амин нэгдлийн тухайн нэг "огт ор үгүй" бүхий цэг, дүр буюу бодгаль ахуй нь л багш хүн юм. Бодот ахуй нь багш хүн бүрийн хувьд өөр өөр агаад харилцан адилгүй хувирдаг учраас бодгаль шинж төрхтэй. Үүнээс тухайн бодот ахуйн илрэл болох хүн хэмээх бодгаль ахуйн тодорхой нэг төлөвийг багш ахуй гэдгийг, багш ахуйтай хувь хүмүүнийг багш хэмээдгийг, багш ахуй тус бүр нь өөр өөр төрх бүхий цэгүүдийн буюу дүрүүдийн багцрахуй болохыг, багш ахуй бол бодгаль шинж төрхтэй гэдгийг, багш ахуйн цэг бүрт харилцан адилгүй бөгөөд өөр өөрөөр хувирч байдаг бодгаль дүр төрх харгалздагийг, багш ахуй нь бодот ахуйн болон хүн хэмээх бодгаль ахуйн дүр болохын хувьд түүн лүгээ бүтэц тогтолцоотой, зүй тогтолтой, жамтайг тус тус түвэггүй анзаарч болох талтай.

Хоёр дахь хөтөч үзэл нь багш хүн бүр суралцаж хүншихүйд суралцсан, тухайлбал, бусад "бүгд"-тэй⁵ харилцахуйд суралцсанаа⁶ ачаар байнга шинэ мэдлэг эзэмшдэг, түүнийгээ шууд хэрэгжүүлэн хүншдэг онцгой чанартай байх ёстойг тодруулж өгч байгаа юм. Эндээс багш хүний энэхүү онцгой чанар эзэмшихүйн үндэс нь бусад "бүгд"-тэй харилцахуйд суралцахуй гэж харагдаж байна. Харилцахуй нь арга болох оролцоо, билиг болох хамтын ажиллагааны нэгдэл. Энэ нь өөрөө бүтээлчээр оролцож, бусад "бүгд"-тэй хамтдаа ажиллахуйг л харилцахуй гэдгийг хэлж буй юм. Арга болохынхоо хувьд оролцоо нь хамтын ажиллагаа болон харилцахуйн эрч буюу хөдөлгөгч хүч болж байдаг хийгээд өөрөө бүтээлч шинжтэй. Иймд бусад "бүгд"-тэй харилцахуйд суралцана гэдэг нь аливаад бүтээлчээр оролцож, хамтарч ажиллахуйд сурсан, бусдыг сургадаг болсон байна гэсэн үг бөлгөө.

Хүмүүний эрхэм чанар (ЭЧ) эзэмшсэн багш хүн л аливаад бүтээлчээр оролцож, бусадтай

хамтран ажиллаж, харилцаж чаддаг. Хүний эрхэм чанарыг хүмүүн өөрийн сурснаа шууд хэрэгжүүлж буюу ажил хэрэг болгож байж л эзэмшдэг. Хүний эрхэм чанар эзэмшсэн багш хүн л бусад түүнийг эзэмшүүлж чаддаг. Хүмүүний эрхэм чанар нь хүнлэг ба шударга ёсны нэгдэл, түүний үр юм. Бусдыг хайрлахуй ба дэмжихүйн нэгдлийг хүнлэг ёс, бусдыг өрөвдөхүй ба хүндлэхүйн цогцыг хайрлахуй, бусад туслах ба бусдыг сонсохуйн багцрахуйг дэмжихүй гэж тус тус ухаарч болно. Харин бусдын өмнө хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлэхийг шударга ёс гэдэг. Өөрийн хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлж байж л сая багш хүний алив оролцоо, хамтын ажиллагаа ба харилцаа өрнөдөг. Өөрийн хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлээгүй тохиолдол бүрт хүмүүний аливаад бүтээлчээр оролцохуй, хамтран ажиллахуй, харилцахуй нь байнга суларч байдаг. Бусдын өмнө хүлээсэн үүргээ ёсчлон биелүүлнэ гэдэг нь сурснаа шууд хэрэгжүүлнэ гэсэн үг. Иймд багш хүн сурснаа шууд хэрэгжүүлж гэмээн аливаад бүтээлчээр оролцон, бусадтай харилцдаг, хамтран ажилладаг хийгээд өөрөө байнга хүншдэг, бусдыг тасралтгүй хүншүүлдэг болох учиртай юм.

Хоёр дахь хөтөч үзлийн дээрх агуулгаас ТХХБ -ын ба тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн өөрөө сурснаа шууд хэрэгжүүлдүүнийхээ ачаар хүмүүний эрхэм чанар эзэмшиж, бусад "бүгд"-тэй харилцахуйд, хамтран ажиллахуйд болон аливаад бүтээлчээр оролцож сурсан, мөн бусдыг тэдгээр сургадаг болсон байх шинж төрхүүд илрэн гарч байгаа юм.

Харин гурав дахь хөтөч үзлээс хүний хэл нь багш хүний онцгой чанар болох суралцаж хүншихүйн үндэс болсон харилцахуйн хэрэглүүр буюу багаж хэрэгсэл гэж харагдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл, багш хүний онцгой чанар болох суралцаж хүншихүй хэлээр дамжигддаг⁷ байна. Харилцахуйн хэрэглүүр буюу хэл сайтай хүн л бусадтай харилцан, тасралтгүй суралцан хүншиж чадна. Үүнийг Монголчууд эрт дээрээс мэдэрч "хэлтэй хүн хөлтэй" гэж томъёолсон байгаа юм. Эхний хөтөч үзлээс хэл сайтай гэдгийн үндэс нь тухайн бодот ахуйнхаа буюу монгол хэлээ сайн эзэмшсэн байх явдал болох нь илэрч байгаа юм. Энэ нь монгол багш хүн хэл сайтай буюу монгол хэлээ гаргууд сайн эзэмших шаардлагтайг тодруулж өгч байна. Монгол хэлний агуулгын ба гаргалгын тал сайтай хийгээд бүх ухааны бичиг үсгийн боловсролтой⁸ болсон багш хүнийг бид

4 Б.Жадамбаа, Нийгэм ба информатик, УБ., 2005.

5 Бусад "бүгд" - тухайн агшин дахь байгаль - нийгэм - соёлын юмс үзэгдэл буюу бодот ахуй. Бусад "бүгд" -тэй харилцахуйд суралцсан - тухайн агшин дахь байгаль - нийгэм - соёлын бүхий л зүйлсийн талаарх наад захын мэдлэг, чадвартай буюу "юм юмны захтай" болсон байна гэсэн үг. 4-р тал.

6 А.А.Леонтьев, Язык, речь, речевая деятельность, М, 1969, стр.207

7 Б.Жадамбаа, Б.Болормаа, Л.Энхбаяр, Тухайн шинжлэх ухааны бичиг үсгийн боловсрол, УБ., 2007.


8 Б.Жадамбаа, Б.Болормаа, Л.Энхбаяр, тухайн шинжлэх ухааны бичиг үсгийн боловсрол, УБ, 2007

монгол хэл сайн эзэмшсэн гэж ойлгож болно. Ухаан нь арга болох хэл, билиг болох сэтгэхүйн нэгдэл учраас монгол ухаан эзэмшихүйн эрч буюу хөдөлгөгч хүч тал нь монгол хэлд суралцахуй юм. Бүх ухаануудын хэлний шүтэлцэн багцрахуй, түүний үр нь монгол хэл учраас манай орны бүх шатны сургалтын байгууллагад ажиллаж буй багш нар бид үнэндээ ямар нэг хэмжээгээр, магадгүй тухайн нэг салбар ухааны өнцгөөс монгол хэлийг л сургаж, сурч, баяжуулан хөгжүүлж байгаа билээ. Гэтэл багш ахуй нь бодот ахуйн дүр тул багш хүн бүр бүх ухааны хэлийг буюу бичиг үсгийн боловсролыг эзэмших, суралцагч хүмүүнийг мөн түүнд сургах шаардлагатай болдог. Үүнээс бид ТХББ ын ба тогтвортой хөгжихүйц багшийн шинжийн нэг нь бүх ухааны бичиг үсгийн боловсрол болон төрөлх хэлээ сайн эзэмшсэн байх явдал гэж үзэж байна.

Багш хүний бүтэц тогтолцоо

Дээрх хөтөч үзлүүд, тэдгээрийн агуулгыг эш үндэс болгон, бид бодгаль ертөнцийн үзлийн арга агаад хэлбэр талын томьёолол болох бодот ахуйн хандлагын хүрээн дэх багш хүний бүтэц тогтолцооны загварын нэгэн хувилбарыг

дэвшүүлэн, түүний бүтэцчилсэн хүрээг уншигч та бүхэнд хэлэлцүүлэхээр 1 дүгээр зурагт дүрслэн үзүүлж байна. 1 дүгээр зургийн зүүн хэсэг нь багш хүн болон түүний бүрдүүлбэрүүдийн билиг талуудыг, баруун хэсэг нь тэдгээрийн арга талуудыг, хэвтээ чиглэлийн дагуух хоёр талт тасархай улаан шугам нь тухайн үрийг (хоёр талт хоёр хар шугамын уулзвар болох) бүтээгч арга билгийн эелдэхүйг буюу шүтэлцэн багцрахуйг (харилцахуйг), босоо тэнхлэгийн дагуух хоёр талт тасархай улаан шугам нь уг хоёр талууд нь харгалзан арга ба билиг болохуйг тус тус илэрхийлж буй болно. Мөн уг зургийн зүүн талын эхлэл болох төрх ба баруун талын төгсгөл болох харилцахуй хоёрыг дайрах хэвтээ тэнхлэгээс доошхи хэсэг болон түүний бүрдүүлбэр бүр харгалзан дээд хагас, түүний бүрдүүлбэрийн мөн чанар, билиг, агуулга талууд юм. Жишээлбэл, багш хүний мөн чанар нь суралцагч хүмүүн хийгээд суралцагч ахуй, хүмүүн нь хүний төрх, суралцагч нь багшийн билиг тал, бодгаль ахуй нь бодот ахуйн илрэл, хүншихүйн хэлбэр нь хүн болохуй, багш ахуйн мөн чанар нь суралцагч ахуй, багш болохуйн мөн чанар нь суралцахуй зэрэг болно.



1-р зураг. Багш ХҮНий бүтэц тогтолцоо

9 Бодгаль ахуй – хүн ахуй.

10 ЭЧ – хүмүүний эрхэм чанар.

11 Бтөрх – багш ахуйн төрх.

12 Бдүр – багш ахуйн дүр.

13 Агуулга – багш боловсролын хөтөлбөрийн төрх.

14 Аргазүй – багш боловсролын харилцахуйн төрх.

15 Бодот ахуй – хүншигч ахуй.

16 Суралцагч хүмүүн – багш хүний мөн чанар тал хийгээд бодгаль ертөнц. Суралцагч хүмүүн хэмээх бодгаль ертөнц өөрөө бодь “огт ор үгүй” ба бод ахуйн нэгдэл учраас түүнийг тус бүр нь өөр өөр бодь “огт ор үгүй” бүхий бод ахуйнуудын багцрахуй гэж үзэж болно.

Уг зураг дахь бодот ахуй (хүншигч ахуй) гэдэг нь тухайн цаг үеийн байгалийн, нийгэм-

соёлын бодот үйл үндсэн болон хүмүүсийн ажил амьдралын үйл ажиллагааны хүрээгээр,

ерөөс тухайн цаг үеийн ажил амьдралын, байгалийн, нийгмийн, соёлын, улс төрийн, эдийн засгийн оюун ухааны үйл явцын багцрахуйгаар тодорхойлогддог. Бодот ахуй нь байгаль-нийгэм-соёлын үйл явц ба цаг хугацааны, байгаль-нийгэм-соёлын үйл явц нь байгалийн ба нийгэм-соёлын үйл явцын, цаг хугацаа нь өнгөрсөн ба ирээдүй цагийн сагцрахуйгаар тус тус илэрхийлэгддэг. Тус бүр нь өөр өөр "огт ор үгүй" (байгаль-нийгэм-соёл-цаг хугацаа, өрх, агуулга, мөн чанар) бүхий зургуудын (цэгүүдийн, дүрүүдийн, хэлбэрүүдийн, шинж чанаруудын) багцрахуйгаар илэрхийлэгдэх нэг ертөнцийн зургийг л бид бодот ахуй гээд буй юм. Хүншигч ахуй гэдэг талаас нь харвал, бодот ахуй гэдэг нь мөнх бусыг туулах явцад хүмүүнд тохиож буй болон тохиох байгаль, нийгэм, соёл, улс төр, эдийн засаг, ёс суртахуун, оюун ухааны үйлийн буюу үзэгдлийн цогц гэж үзэж болно. Хүншигч ахуй нь хүн, багш, суралцагч ахуйн мөн чанар учраас тэдгээрийн дүр төрх хүншигч ахуйнх лугаа байдаг. Жишээлбэл, хүншигч ахуйн экологийн тэнцвэр алдагдах тохиолдолд хүн, багш, суралцагч ахуйн хөгжил мөн адил тогтворгүй болдог. Иймд тогтвортой хөгжихүйц хүншигч ахуйтай байж хэмээн, ТХББ -той, тогтвортой хөгжихүйц боловсролтой багштай, хүмүүстэй болж чаддаг. Тэрчлэн, ТХХБ ба тогтвортой хөгжихүйц боловсролтой багштай болж байж, сая бид бодот ахуйгаа буюу хүншигч ахуйгаа тогтвортой хөгжихүйц болгож чадна.

Багш хүний бүтэц тогтолцоон дахь багш ахуй гэдэг нь нэг талаас, бодот ахуйн илрэл болох хүн хэмээх бодгаль ахуйн илрэл, нөгөө талаас, тухайн багш хүний ажил амьдралын үйл ажиллагааны үндсэн хүрээний цогц, ерөөс багш хүний ажил амьдралын болон байгалийн, нийгмийн, соёлын, улс төрийн, эдийн засгийн, оюун ухааны талаарх үйл ажиллагааны багцрахуйгаар тодорхойлогддог. Үүнээс бид багш ахуй гэдгийн дор тус бүр нь өөр өөр огторгуй-хугацаа бүхий багш хүний дүрүүдийн буюу зургуудын нэгдлээр тодорхойлогдох багш хүний ертөнцийн зургийг ойлгож болно.

1 дүгээр зураг дахь бодгаль ахуй (хүн ахуй) гэдэг нь нэг талаас, бодот ахуйн дүр, нөгөө талаас хүмүүний бие ба сэтгэцийн шүтэлцэн багцрахуй, түүний үр болох сэтгэлийн орон юм. Тус бүр нь өөр өөр "огт ор үгүй" бүхий цэгүүдийн буюу тухайн хүмүүний санаа бодлын багцрахуйг бид түүний бодгаль ахуй буюу сэтгэлийн орон хэмээдэг. Уг зургаас, сэтгэлийн орон нь багш болон суралцагч ахуйн мөн чанар гэж харагдаж байгаа юм. Энэ нь багш хүн сурах, сургах буюу суралцах сэтгэлтэй л байх явдал хамгийн чухал гэдгийг хэлж өгдөг.

Хүн ахуйн үүднээс бол, бодгаль ахуй гэдэг нь хүмүүний хүсэл тэмүүллийн багцрахуй юм.

Бодгаль ахуйн дүр агаад багш ахуйн төрх болох суралцагч ахуй нь суралцагч хүмүүний орших, бусадтай нийгэмшин амьдрах, мэдэх, бүтээх хэрэгцээгээ ухамсарлах үйл ажиллагааны цогц, тухайлбал, суралцагч хүмүүний ажил амьдралын, байгалийн, нийгмийн, соёлын , улс төрийн, эдийн засгийн, оюун ухааны үйл явцын утга учрыг ухаарч ухамсарлах үйл ажиллагааны нэгдэл юм. Суралцагч ахуй тус бүр нь өөр өөрийг сурах хүсэл эрмэлзэл бүхий суралцагч дүрүүдийн буюу зургуудын харилцан нөхцөлдөхүйн үр болох суралцагч хүмүүний ертөнцийн зураг.

1 дүгээр зурагт үзүүлсэн, багш хүний бүтэц тогтолцооноос багш хүний мөн чанар, агуулга, билиг тал нь хүн, шинж чанар, хэлбэр, арга тал нь багш: багш хүн нь арга болох багш , билиг болох хүний нэгдэл; багш хүний аргын арга тал нь багш болохуй (суралцахуй), билиг тал нь багш ахуй (суралцагч ахуй); багш хүний билгийн арга тал нь хүн болохуй (хүншихуй), билиг тал нь бодгаль ахуй (суралцагч ахуй); багш хүн гэдэг нь суралцагч хүмүүн; багш болохуйн буюу суралцахуйн фрактал бүтэц нь багш ахуй, агуулга, суралцагч ахуй; бодгаль, багш, суралцагч ахуйнууд нь бодот ахуйн дүр; хүмүүн, хүн, багш нь мөн бодот ахуйн дүр; багш болохуйн мөн чанар нь хүн болохуй; багш бүр суралцагч, багш хүн бүр суралцагч хүмүүн; багш хүн болохуйн мөн чанар нь хүний эрхэм чанар эзэмшихүй; суралцаж багш болдог, сурснаа хэрэгжүүлж хүн болдог; багш хүн болохуй нь билиг болох хүн болохуй ба арга болох багш болохуйн нэгдэл; бодот ахуйн дүр нь бодгаль ахуй, бодгаль ахуйн дүр нь багш ба суралцагч ахуй; багш ахуйн төрх ба дүр нь бодот болон бодгаль ахуйн төрх ба дүрийн илрэл; багш хүний тогтолцоог билиг талаас нь хүн, арга талаас нь багш, арга билгийн нэгдэлд нь багш хүн хэмээн тодорхойлдог; хүн болохуйн (хүншихуйн) үр нь бодгаль ахуй (бодгаль дүр төрх), багш болохуйн (суралцахуйн) үр нь багш ахуй (багш дүр төрх); багш хүний ахуй бодгаль нь бодтыг, бодот нь багшийг, багш нь суралцагч ахуйг ээлж дараалан өөртөө агуулах замаар тасралтгүй өргөжин тэлж байдаг; багш хүн хүмүүн нь хүн, хүн нь багш, багш нь суралцагч болж, байнга хөгжиж байдаг; хүн, багш хүн, багш, суралцагч хүмүүн, суралцагч, багш ба хүн болохуй (суралцахуй ба хүншихуй) болон тэдгээрийн ахуй хийгээд мөн чанар, шинж чанар, хувирал өөрчлөлт нь бүгд л бодот ахуйн үзэгдэл гэдэг нь тус тус харагдаж байгаа юм.

Өмнөх зурагт үзүүлсэн багш хүний бүтэц

тогтолцоо, түүний бүрдүүлбэр бүр нь арга талаа даган билиг хөдлөнгө, билиг талаа түшин арга зогсонги болох замаар тасралтгүй хувьсч өөрчлөгддөг.

1 дүгээр зургаас багш хүн, түүний боловсролын асуудлыг багш, хүн, багш хүн зэрэгт харгалзах арга, билиг, арга билгийн нэгдэл гэсэн гурван талаас авч үзэх боломж харагдаж байгаа юм. Эдгээр боломжийн цаана багш гэсэн арга ба багш хүн хэмээх арга билгийн талаас хардаг Өрнийн, хүн болох билиг ба багш хүн хэмээх арга билгийн нэгдэл талаас нь авч үздэг Дорны сэтгэлгээ оршин байдаг. Зөвхөн арга болох багш буюу билиг болох хүн гэсэн нэг өнцгөөс авч үзэж буй багш боловсролыг тогтворгүй багш боловсрол, түүний үрийг тогтворгүй боловсролтой багш гэж тодорхойлж болох юм. Харин ТХББ ба тогтвортой хөгжихүйц боловсролтой багш гэдэг нь арга ба билгийн нэгдэлд нь багш хүн гэсэн талаас авч үзсэн багш боловсрол, түүний үр юм байна хэмээн ойлгож болно.

ТХББ-ын ба тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн дүр төрх

ТХББ нь хүмүүнд шингэн нөхцөлдөж, түүнийг тогтвортой хөгжихүйц боловсролтой багш болгон хувирган өөрчилдөг төдийгүй түүний шинж чанарыг бүрэн илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, ТХББ нь багш хүний мөн чанар хийгээд илрэл юм. Илрэлийг нь л бид тогтвортой хөгжихүйц боловсролтой багш гээд буй болно. Иймд бид тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн дүр төрхийг тодорхойлохын тулд юуны өмнө түүний мөн чанар болох ТХББ-ын байдал төрхийг тодруулах хэрэгтэй байгаа юм. Энэ нь хэрвээ ТХББ-ын дүр төрхийг тодруулах аваас түүний илрэл болох тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн дүр төрх бидэнд ил болно гэдгийг л хэлж буй юм. Үүнийг бид энэ ажилд бодгаль ертөнцийн хандлагын хүрэн дэх багш хүний бүтэц тогтолцооны (1-р зураг) тусламжтайгаар, дараах байдлаар тодруулан уншигч та бүхэнд танилцуулж байна.

Тогтвортой хөгжихүйц багш боловсрол хэмээх ухагдахуун нь ердийн багш боловсролоос “тогтвортой” ба “хөгжихүйц” гэсэн хоёр тодотголоор ялгаатай. Багш боловсролыг зөвхөн шинж чанар буюу мөн чанар гэсэн нэг өнцгөөс бус, агуулга ба хэлбэрийн нэгдэлд нь 1 дүгээр зураг дахь багш хүн тогтолцооны дагуу түүний бүрдүүлбэрүүдийг арга ба билиг талуудаар нь эелдүүлэн нэг цогц болгон авч үзэх санаа “тогтвортой” хэмээх тодотголд үйлдэгдсэн байгаа юм. Харин “хөгжихүйц” хэмээх тодотгол багш

боловсрол нь багш хүн бүр суралцаж хүншихүйд сурч, тасралтгүй зөв сэтгэлтэй буюу бодолтой, зөв мэдлэгтэй, зөв үйлтэй, зөв яриатай, зөв хичээл зүтгэлтэй, зөв харилцаатай, зөв төвлөрөлттэй, зөв амьдрахуйтай болдог төдийгүй бусдыг суралцаж хүншихүйд сурган, тасралтгүй ахин дэвшдэг болгодог байх ёстойг тодорхойлж өгч байгаа юм. Товчоор хэлбэл, “тогтвортой” ба “хөгжихүйц” хэмээх тодотголууд нь харгалзан, ТХББ-ын агуулга ба аргазүйг (мөн чанар ба шинж чанарыг, агуулга ба хэлбэрийг, төрхийг ба дүрийг) боловсруулан, үйл хэрэг болгоход баримталбал зохих шаардлагуудын цогцыг тус тус тодорхойлогч болж таарч байна.

Эдгээрээс тус бүр нь харилцан адилгүй багш хүний тэр олон ахуйн шүтэлцэн багцрахуйг бид ТХББ -ын дүр төрх гэж үзэж болно. Багш хүний ахуй нь нэг талаас, багш ба хүний бодгаль ахуйн, нөгөө талаас, багш хүний агуулга ба аргазүйн нэгдэл. Иймд ТХББ-ын дүр төрх гэдгийн дор түүний агуулга аргазүйн нэгдлийг ухаарч болно.

Бодот ахуйн хандлагын хүрэн дэх багш хүний бүтэц, тогтолцооноос (1-р зураг) урган гарч буй “тогтвортой хөгжихүйц” гэсэн тодотголын утга санааны үндсэн дээр бид ТХББ -ын агуулга, аргазүй нь:

- Багш хүний бүтэц тогтолцоонд иж бүрэн тохирсон байх, тухайлбал, тэдгээр нь арга ба билиг талаараа шууд буюу дам хэлбэрээр бусад бүх бүрдүүлбэртэй харилцан уялдсан байх
- Багш хүний мөн чанар нь хүн, шинж чанар нь багш; багш ахуйн мөн чанар нь бодот, бодгаль, суралцагч ахуй; багш болохуйн мөн чанар нь хүн болохуй, хүншихүй, суралцахуй; багшийн төрх нь бодот, бодгаль, суралцагч ахуйн төрхүүдийн нэгдэл; багшийн дүр нь бодот, бодгаль, суралцагч ахуйн дүрүүдийн багцрахуй; суралцаж агуулгыг эзэмшдэг, түүнийгээ шууд хэрэгжүүлэн, хүмүүний эрхэм чанартай болдог; багш хүн нь суралцагч хүмүүн хийгээд багш нь суралцагч; багш болохуйн ба багш байхуйн үндэс нь тухайн багш хүмүүний бодгаль буюу сэтгэлийн орон гэх мэт 1 дүгээр зураг дахь багш хүний бүх боломжит онцлог, шинж төрхийг тооцсон байх
- Хичээл бүрийнхээ агуулга, аргазүйн мөн чанар буюу илрэл
- Бодот буюу хүншигч, бодгаль агаад хүн, суралцагч, багш ахуйн онцлогийг бүрэн тооцсон, тэдгээрт бүрэн нийцсэн байх
- Багш болохуй ба хүн болохуйг болон суралцахуй ба хүншихүйг нэгдэлд нь авч үзэн, хэрэгжүүлэхүйц байх

- Тухайн чиглэл бүрээрээ суралцагчийг бүх ухааны хэл буюу бичиг үсгийн боловсрол¹⁷ болон хүмүүний эрхэм чанар эзэмшүүлэх¹⁸ хийгээд суралцах хүншихүйд, аливаад оролцохуйд, бусадтай ажиллахуйд, харилцахуйд сургахаар төлөвлөгдөн, хэрэгждэг байх
- Багш хүний бүтэц тогтолцооны бүрдүүлбэр бүрийн олон хэрэгцээний нэгдлийг бүрэн тусгасан хийгээд хангахуйц байх
- Үйлийн буюу ажиллах явцад суралцахуйц үндэслэсэн байх
- Боловсруулах, хэрэгжүүлэх, шинжлэн үнэлэх үйл ажиллагаа бүр нь нээлттэй бөгөөд сонирхлын бүлгүүд байнга бүтээлчээр оролцон, хамтран ажиллах боломжтой байх шаардлагатай.

Энэхүү нийтлэг шаардлагын цогц нь ТХХБ-ын болон тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн төрх ба дүрийг хийгээд мөн чанар ба шинж чанарыг, багшийн боловсрол тогтвортой хөгжихүйц байна уу, эсвэл үгүй байна гэдгийг тус тус шинжих боломжийг бидэнд олгодог. Уг нийтлэг шаардлагын цогцтой тохироо сайн байгаа багш боловсролыг ТХББ, түүний илрэлийг тогтвортой хөгжихүйц боловсролтой багш эсрэг тохиолдолд тогтворгүй хөгшижихүйц багш боловсрол, багшийг тогтворгүй хөгжихүйц боловсролтой гэж тус тус ойлгодог. Үүнээс багшийг тогтвортой хөгжихүйц боловсролтой болгон хувирган өөрчлөхийн буюу ТХББ-ын үндэс нь өнөөгийн Монголын багш боловсрол ба ТХББ -ын нийтлэг шаардлагын тохироо нийцлийг сайжруулах тухай асуудал юм. Тохироо нийцлийг бид, багш хүний загварын аргын арга талыг илэрхийлэгч багш болохуйн хөтөлбөр, түүнийг ажил хэрэг болгох үйл ажиллагааны багцад тусган хэрэгжүүлэх замаар сайжруулах ёстой.

Өмнө өгүүлснээр, ТХББ-ын нийтлэг шаардлага нь багш хүний тогтолцооны бүрдүүлбэр бүрийн шаардлагуудын нэгдэл юм. Тэдгээр шаардлагууд нь тухайн бүрдүүлбэр бүрийн хэрэгцээнүүдийн багцрахуйгаар илэрхийлэгддэг. Эдгээр хэрэгцээний нэгдэл нь ТХББ-ын болон тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн хэрэгцээний бүтэцчилсэн хүрээг тодорхойлох учиртай.

Жишээлбэл, тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн бодот ахуйн хэрэгцээ нь өнөөгийн Монгол орны байгалийн, нийгмийн, соёлын, улс төрийн, эдийн засгийн, оюун ухааны,

хүмүүсийн ажил амьдралын буюу байгаль-нийгэм-соёл-цаг хугацааны үйл явц, тэдгээрт тавигдаж буй шаардлага, тэдгээрийн тулгамдсан асуудлуудын цогцоор тодорхойлогддог. Харин тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн багш ахуйн хэрэгцээ нь нэг талаас, бодгаль ба суралцагч ахуйн нөгөө талаас тухайн багш хүний оршихуйн болон ажиллаж амьдрахуйн шаардлагын нэгдлээр тус тус илэрхийлэгддэг.

Тогтвортой хөгжихүйц боловсролтой багш гэдэг нь багш хүний бүтэц тогтолцооны хэрэгцээний цогцтой тохироц сайтай, түүнийг хангахуйц багш ахуй бүхий л хүмүүн юм. Хүмүүний тогтвортой хөгжихүйц боловсролтой багш болох хэрэгцээг бүрэн дүүрэн, чанартай хангах үйлчилгээний багцрахуйг бид ТХББ гэдэг. Тэрхүү чанартай үйлчилгээний багцрахуйг үзүүлдэг байгууллагыг багш бэлтгэх их, дээд сургууль, тэнд ажиллаж буй багш нарыг багшийн багш гэж тус тус нэрлэж байгаа юм. Эндээс ТХББ эзэмшсэн, түүнийгээ шууд ажил хэрэг болгох чадамжтай хүмүүнийг тогтвортой хөгжихүйц боловсролтой багш хүн хийгээд тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн багш гэж нэрлэж болно.

Өмнө өгүүлсэн, ТХББ-ын дүр төрхийг туршин хэрэгжүүлэх, үр дүнг шинжих, цаашид боловсронгуй болгох бүхий үйл ажиллагаанд:

- Бүх салбарыг, түвшнийг төлөөлсөн сонирхлын бүлгийн бүтээлч оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлах
- Багш хүн ба удирдлага төвтэй хандлагуудыг хослуулах
- Нээлттэй хийгээд ил тод байх
- Оролцогч бүр бие биеэ шүүмжлэх бус дэмжих
- Хамтдаа шийдвэр гаргах
- Аливааг үйлийн явцад суралцахуйн үндсэн дээр тасралтгүй сайжруулах зэрэг стратегийг баримтлах ёстой.

Цаашид энэхүү ажилд бидний дэвшүүлж буй бодот ахуйн хандлагын багш хүний талаарх хөгөч үзэл, багш хүний бүтэц тогтолцоо, ТХББ -ын ба тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн загвар, мөн чанар ба шинж чанар, агуулга ба арга зүй, тэдгээрт тавигдах үндсэн шаардлага, тэдгээрийг хэрэгжүүлэх стратеги зэргийг төлөвлөх, үйл хэрэг болгох, үр дүнг шинжлэн үнэлэх үйл ажиллагааг эхлүүлэн, түүнийг тасралтгүй шинжин сайжруулж, хөгжлийн чиг зүгийг тодорхойлж байх хэрэгтэй. Үүнийг бид ТХББ-ыг ба тогтвортой хөгжихүйц боловсролтой

¹⁷ Б.Жадамбаа, Б.Болормаа, Л.Энхбаяр, тухайн шинжлэх ухааны бичиг үсгийн боловсрол, УБ, 2007

¹⁸ Богд Зонхов, Бодь мөрийн зэрэг, УБ, 2006, х.8,27

багшийг шинжсэнээр ажил хэрэг болгох боломжтой юм.

ТХББ-ыг болон тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийг шинжихүйц

Багш боловсролын хөгжлийн диалектик зүй тогтлын нэг орчил болох ТХББ-ын үзэл санааг оновчтой хэрэгжүүлэх, тогтвортой хөгжихүйц боловсролтой багштай болох ажлыг эхлүүлэн, үйлийнхээ явцад тасралтгүй суралцан, тэдгээрийг байнга сайжруулж байхын тулд бид юуны өмнө тэдгээрийг шинжихүйн үр агаад чиг зүгийг заагч шинжүүрийн бод ахуйг тоймлох нь чухал юм. Алив зүйлийн шинжүүр нь түүний шинжих үйлийн үр төдийгүй ахиц дэвшлийг чиглүүлэгч, хөдөлгөгч хүч болдог учраас, тогтвортой хөгжихүйц багш боловсролын санааг нэвтрүүлэн, тогтвортой хөгжихүйц боловсролтой багш нартай болох ажлыг эхэлж буй бидний хувьд, тэдгээрийн шинжүүрийн төрлүүд, тэдгээрт харгалзах шалгуур үзүүлэлтийг оновчлон тодорхойлох шаардлага нэн тулгамдсан асуудал болоод байгаа юм.

ТХББболонтогтвортойхөгжихүйцболовсролтой багш нь бодот ахуйн буюу байгаль-нийгэм-соёлын-цаг хугацааны үзэгдэл учраас тэдгээрийг шинжих үйл, түүний үр болох шинжүүр мөн л бодот ахуйн буюу байгаль-нийгэм-соёл-цаг хугацааны үзэгдэл байж таарна. Энэ нь ТХББ-ыг болон тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийг шинжих үйлийн болон шинжүүрийн бод ахуй тус бүр нь харилцан адилгүй “огт ор үгүй” (байгаль-нийгэм-соёлын-цаг хугацаа) бүхий шинжих үйлүүдийн болон шинжүүрүүдийн багцрахуйгаар илэрхийлэгддэг гэдгийг хэлж буй юм.

Шинжүүр гэдэг нь нэг талаас, шинжих үйлийн үр¹⁹, нөгөө талаас арга болох шалгуур, билиг болох үзүүлэлтийн нэгдэл, түүний үр болох шалгуур үзүүлэлт юм. Үзүүлэлт ба шалгуур нь шинжүүр оршихуйн хоёр хязгаар дахь илрэл агаад эл хязгаарынхаа хооронд тэр хоёр амьсан шүтэлцэхүйн жамаар нэг чанарыг үүсгэдэг. Тухайлбал, энд авч үзэж буй үзүүлэлт ба шалгуур нь ТХББ-ын нэг амь багцралд шингэж, түүний шинж чанарыг бүрэн илэрхийлдэг. Тэгэхлээр ТХББ нь түүний шалгуур үзүүлэлт оршихуйн мөн чанар хийгээд илрэл юм.

Нэгэнт бодот ахуй болох байгаль-нийгэм-соёл цаг хугацаа нь ТХББ-ын мөн чанар учраас тэр мөн түүний шалгуур үзүүлэлтийн мөн чанар бөгөөд илрэл байх ёстой. Чухамдаа энэ нь ТХББ-ын шинжүүр бодот ахуйн үзэгдэл болохыг л гэрчилж буй юм.

ТХББ-ын шинжүүр шалгуураа даган, үзүүлэлт

хөдлөнгө, үзүүлэлтээ түшин шалгуур зогсонги болох замаар тасралтгүй хувьсан өөрчлөгддөг. Ийм учраас ТХББ-ын шинжүүр гэдгийг арга ба билгийн нэгдэл талаас нь шалгуур үзүүлэлт, арга талаас нь шалгуур, билиг талаас нь үзүүлэлт хэмээн тус тус олон янзаар ухаарч, ярьж, бичиж болох юм. Бид энэ ажилд ТХББ-ын шинжүүрийг аргын буюу билгийн гэсэн аль өнцгөөс бус, арга ба билгийн нэгдэл талаас нь шалгуур үзүүлэлт гэдэг утгаар авч үзэв.

Дээр хэлсэнчлэн, бодгаль ертөнцийн хандлагын хүрэн дэх ТХББ-ыг шинжих үйлийн үр болох шинжүүр тус бүр нь харилцан адилгүй төрх бүхий дүрүүдийн багцрахуй болох бод ахуй юм. Үүнээс ТХББ-ын шинжүүрийг тодорхойлно гэдгийг бид түүний бод ахуйн цэг бүр дэх өөр өөр төрх бүхий дүрийг судлан тогтоохуй гэж ухаарч болно. Уг дүрийн тасралтгүй цувраа түүний ертөнцийн зургийг бүрдүүлдэг. Шинжүүрийн бод ахуйн цэг бүр дэх харилцан адилгүй төрх бүхий дүрийг судлан тогтоохын тулд ТХББ-ын илрэл болох багш хүний бүтэц тогтолцооны ямар нэг загвар хэрэгтэй болдог. Эл зорилгын үүднээс л бид багш хүний бүтэц тогтолцооны нэгэн хувилбарыг бодгаль ертөнцийн хандлагын хүрээнд дэвшүүлэн, 1 дүгээр зурагт үзүүлсэн билээ.

Судалгааны индукцийн ба дедукцийн²⁰ аргуудыг нэгдэлд нь авч үзэн, 1 дүгээр зурагт үзүүлсэн багш хүний бүтэц тогтолцооны загварын тусламжтайгаар ТХББ -ын шинжүүрийн бод ахуйг судлан тогтоох доорх аргачлалыг бид энэ ажлаар та бүхэнд танилцуулж байна.

ТХББ-ын шинжүүрийн бод ахуй нь хэмжээлшгүй тооны, өөр өөр төрх бүхий дүрүүдийн багцрахуй. Иймд бид эхлээд 1 дүгээр зурагт үзүүлсэн багш хүний бүтэц тогтолцооны загвар, ТХББ-ын агуулга, арга зүй, тэдгээрийн үндсэн шаардлагыг иш үндэс болгон, түүний тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтыг тодорхой болгон оновчлох шаардлагатай. Тэргүүлэх чиглэл ба зорилго гэдэг нь ТХББ -ын “огт ор үгүй” тал болох судлах зүйлс юм. Гэхдээ тэргүүлэх чиглэл нь ТХББ -ын “огт ор үгүй”-н тухайн нэг төрх буюу бодь “огт ор үгүй”, зорилго нь дүүний дүр бодь ахуй юм. Тэргүүлэх чиглэл, зорилгыг маш тодорхой болгон оновчлохуй нь бодтой, утга төгс шинжүүрийн бод ахуйтай болохуйн үндэс юм. Шинжүүрийн бод ахуй нь эргээд мөн зорилго болон тэргүүлэх чиглэлийг нарийвчлахад тус нэмэр болдог. ТХББ-ын зорилго, тэргүүлэх чиглэлийг оновчлоход үндэсний хэмжээний

¹⁹ “Мысльне выражается, но совершается в слове”-Л.С.Выгодский, Избранные психологические исследования, М.1956, стр 332

²⁰ Б.Жадамба, Ц.Чимэдлхам, Судалгааны аргазүй, Уб., 2000, 25-30-р тал.

ТХББ-ын бодлого чиглэл тодорхой болсон байх явдал хамгаас чухал. Мөн ТХББ-ын зорилго, тэргүүлэх чиглэл харгалзах шинжүүрийн бод ахуйг тодорхойлох үйлийн эхнээс л сонирхлын бүлгүүдийг идэвхтэй оролцуулан, тэдэнтэй хамтран ажиллах нэн чухал.

ТХББ-ын зорилго, тэргүүлэх чиглэлийг оновчилсноор, тэдгээрийн дүр, судлахуун, хэлбэр, шинж чанар, арга тал болох зорилтыг тодорхойлох боломжтой болдог. ТХББ-ын зорилт нь тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, бодтой, хугацаандаа хүрэхүйц байх шаардлагатай¹³²¹ байдаг. Зорилт нь зорилгын дүр учраас, нэг зорилго нь хоорондоо уялдаа холбоо бүхий, тус бүр нь өөр өөр агуулгатай зорилтуудын цогц (2-р зураг) юм. Шинжүүрийн бод ахуй нь зорилтын дүр учраас зорилт нь шинжүүрийн бод ахуйг ТХББ-ын зорилго болон тэргүүлэх чиглэлтэй холбож өгдөг. Зорилтоос шинжүүрийн бод ахуйг гарган авах нь түүнээс үүдэлтэй ахиц дэвшлийг ил болгож өгдөгөөс гадна мөн үргэлжлүүлэн урьдчилан харж чадаагүй бусад үр дүнг тодорхойлох боломж бүрдүүлж өгдгөөрөө онцлогтой.

Эндээс сонирхлын бүлгүүдийн анхаарлыг ТХББ-ын талаарх үүсгэл санаачилга, түүний явц, ололт зэрэг үе шат тус бүрт төвлөрүүлэхийн тулд эхнээсээ л оновчтой шинжүүрийн бод ахуйг бүгдийн оролцоо, хамтын ажиллагааны үндсэн дээр тодорхойлох шаардлагатай. ТХББ-ын шинжүүрийн бод ахуй нь түүний хувьслын чиг хандлагыг зааж өгдөг тул түүнийг боловсруулахад сонирхлын бүлгүүд идэвхтэй оролцож чадах аваас тэд хамтдаа тэр зүг үрүү л тэмүүлдэг. Түүнийхээ ачаар ч тэд өөрсдийн хамтран тодорхойлсон шинжүүрийн бод ахуй, түүний тухайн бүрдүүлбэрүүдэд харгалзах ТХББ-ын дүр (зорилт) төрх (зорилго ба тэргүүлэх чиглэлийн)-ийн талаарх тодорхой хамтын үр дүнгүүдийг бүтээн бий болгодог. Чухамдаа ТХББ-ын шинжүүрийн бод ахуйг л хамтдаа боловсруулж гэмээн, сая түүний хүрэн дэх сонирхлын бүлгүүдийн оролцоо, хамтын ажиллагаа жинхэнэ ажил хэрэг болж чадна.

ТХББ-ын дүр төрх, түүний ахиц дэвшлийг баримжаалах шинжүүрийн бод ахуй нь цэг тус бүр дэх өөр өөр шинжүүрүүдийн багцрахуйгаар илэрхийлэгддэг. Шинжүүр нь төрх болох шинжүүрийн төрөл, дүр болох шалгуур үзүүлэлтийн нэгдэл, түүний үр. Шинжүүрийн төрх нь зорилтын агуулга буюу мөн чанар тал учраас зорилтын тухайн үеийн бодот байдал, хэрэгжилт,

үр дүнгийн нэгдэлээр тодорхойлогдох учиртай. Иймд бид шинжүүрийн төрхийг бодот байдлын, хэрэгжилтийн, үр дүнгийн гэсэн хоорондоо уялдаа холбоо бүхий гурван төрлийн цогц гэж үзэж болох юм. ТХББ-ын шинжүүрийн бодот байдлын төрөл нь түүний тухайн агшин дах дүр зургийг, хэрэгжилтийн төрөл нь түүний хөдлөл хувирлын явцыг, үр дүнгийн төрөл нь хүрсэн түвшин буюу ололт амжилтыг тус тус илэрхийлдэг.

Шинжүүрийн төрхийн төрөл бүр нь өөр өөрийн дүр болох шалгуур үзүүлэлтийн багцыг үүсгэдэг. Шалгуур үзүүлэлт нь төрх болох үзүүлэлт тэргүүлэх чиглэлийн)-ийн талаарх тодорхой хамтын үр дүнгүүдийг бүтээн бий болгодог. Чухамдаа ТХББ-ын шинжүүрийн бод ахуйг л хамтдаа боловсруулж хэмээн, сая түүний хүрэн дэх сонирхлын бүлгүүдийн оролцоо, хамтын ажиллагаа жинхэнэ ажил хэрэг болж чаддаг.


ТХББ-ын дүр төрх, түүний ахиц дэвшлийг баримжаалах шинжүүрийн бод ахуй нь цэг тус бүр дэх өөр өөр шинжүүрүүдийн багцрахуйгаар илэрхийлэгддэг. Шинжүүр нь төрх болох шинжүүрийн төрөл, дүр болох шалгуур үзүүлэлтийн нэгдэл, түүний үр. Шинжүүрийн төрх нь зорилтын агуулга буюу мөн чанар тал учраас зорилтын тухайн үеийн бодот байдал, хэрэгжилт, үр дүнгийн нэгдэлээр тодорхойлогдох учиртай. Иймд бид шинжүүрийн төрхийг бодот байдлын, хэрэгжилтийн, үр дүнгийн гэсэн хоорондоо уялдаа холбоо бүхий гурван төрлийн цогц гэж үзэж байна.

Төгсөгч бүр суралцаж хүншихүйд сурсан байх

ТХББ-ын шинжүүрийн бодот байдлын төрөл нь түүний тухайн агшин дахь дүр зургийг, хэрэгжилтийн төрөл нь түүний хөдлөл хувирлын явцыг, үр дүнгийн төрөл нь хүрсэн түвшин буюу ололт амжилтыг тус тус илэрхийлдэг.

Шинжүүрийн төрхийн төрөл бүр нь өөр өөрийн дүр болох шалгуур үзүүлэлтийн багцыг үүсгэдэг. Шалгуур үзүүлэлт нь төрх болох үзүүлэлт, зураг болох шалгуурын нэгдэл юм. Үүнээс бид үзүүлэлт нь тухайн төрлийн агуулга, мөн чанарыг, шалгуур нь түүний хэлбэр, шинж чанарыг тус тус илэрхийлдэг байна. Иймд бид тухайн төрлийн үзүүлэлт нь түүний чанар, шалгуур нь түүний тоон талыг мөн тус тус тодорхойлдог гэж ойлгож болно. Жишээ болгон, тэргүүлэх чиглэл болох “суралцаж хүншихүйд сурахуй”-н “төгсөгч бүр суралцаж хүншихүйд суралцсан байх” гэсэн зорилгын нэгэн дүр болох "багшийн багш бүр суралцаж хүншихүйд суралцсан байна" зорилтоос түүний шинжүүрийн төрөл, төрөл тус бүрт

²¹. Үүнийг бид ТХББ-ын 8МАК.Т (8- Spec1ic, М- Meazigable, А - АИатаible, К - ЯеаНвйс, Т - Т1те-Боипс1) буюу ТХХБХ (Т - Тодорхой, Х -Хэмжигдэхүйц, Х - Хүрч болохуйц, Б - Бодтой, Х - Хугацаандаа хүрэхүйц) байр байдал гэдэг.



харгалзах шалгуур үзүүлэлтийг судлан тогтоохуйн бүтэцчилсэн хүрээг авч үзье (3-р зураг).

Өмнө өгүүлсэнчлэн, уг шинжүүр нь дүр зургийн, хэрэгжилтийн, үр дүнгийн гэсэн төрөлтэй. Энэ тохиолдолд, дүр зургийн төрлийн үзүүлэлтийг “багшийн багш бүрийн суралцаж хүншихүйд суралцсан байдал”, шалгуурыг “багшийн багш нарын ...% суралцаж, хүншихүйд суралцсан байна” гэж тодорхойлж болно. Харин хэрэгжилтийн буюу үйл явцын төрлийн үзүүлэлт нь “багшийн багшид суралцаж хүнших хэрэгцээ, сэдэл бий болсон эсэх”, “багшийн багш суралцаж хүнших хэрэгцээ сэдлээ ажил хэрэг болгох үйл ажиллагаагаа оновчлон төлөвлөсөн, эсэх”, “багшийн багш суралцаж хүншихүйд суралцаж буй байдал” гэх мэт бол, шалгуур нь харгалзан “багшийн багшийн ...% суралцаж хүншихүйн талаарх сургалтад хамрагдсан”, “багшийн багшийн ...% суралцаж хүншихүйд суралцах тодорхой төлөвлөгөөг хэрэгжүүлсэн”, “багшийн багшийн ...% суралцаж хүншихүйд суралцаж байгаа талаар бусадтайгаа санал солилцон, хамтарч ажиллаж байгаа” зэрэг болно. Үр дүнгийн төрлийн үзүүлэлт нь “бүтээгдэхүүн бий болсон эсэх”, “үр дагаврын байдал”, “нөлөө бий болсон эсэх”, “ололт амжилт гарсан эсэх” гэх мэт бол шалгуур нь харгалзан “багшийн багш анрын ...% суралцаж хүншихүйн туршлага, сургамжаа эмхэтгэн, оюутан багшид зориулсан зөвлөмж

гаргасан”, “багшийн багшийн ...% суралцаж хүншихүйд суралцах зайлшгүй хэрэгтэйг ойлгосон”, “суралцаж хүншихүйд суралцахуй нь багшийн багшийн ...% -ийн ээлжит хичээлийн арга зүйгээ өөрчлөхөд нөлөөлсөн эсэх”, “багшийн багшийн ...% суралцаж хүншихүйд суралцахуйдаа амжилт олсон эсэх” зэрэг гэж үзэж болно.

ТХББ-ын шинжүүрийн төрх, түүний төрөл нь тухайн улс орны, бүсийн, аймгийн, сумын, багийн болон чухам аль салбарын, чиглэлийн онцлог, бодот хэрэгцээ, шаардлагаас хамаарч олон янз бүтэц тогтолцоотой. Ийм учраас ч Монголын ТХББ-ын шинжүүрийн бүтэцчилсэн хүрээг нэгэн утгатайгаар, иж бүрэн тодорхойлохуй нь асар их цаг хугацаа, хүч чармайлт шаарддаг түвэгтэй ажил юм.

Улс орон бүр өөр өөрийн онцлогт тохирсон үндэсний ТХББ-ын шинжүүрийн бүтэцчилсэн хүрээг буюу бод охуйг боловсруулах шаардлагатай болдог. Тухайн орны ТХББ-ын шинжүүрийн бод ахуйн зарим хэсэг нь бүс нутгийнхаа бусад орныхтой төсөөтэй буюу адилавар байдаг.

ТХББ-ын шинжүүрийн бод ахуй нь тогтвортой хөгжлийн, тогтвортой хөгжихүйц боловсролын шинжүүрийн бод ахуйн дүр юм.

Тогтвортой хөгжлийн шинжүүр нь орчны, ажил хэргийн болон жендерийн тэгш байдлын гэх мэт талбарт бий болсон өөрчлөлтийг хянаж хэмждэг. ТХБ-ын шинжүүр нь боловсролын тогтолцооны, сургуулийн хүрээний үр дүн болох

ололт амжилт, тестийн үр дүн, тоо тоолол, бичиг үсэг, үндэсний стандарт зэргийн тогтвортой хөгжихүйц байдлыг хянадаг. ТХББ-ын шинжүүр нь тогтвортой хөгжлийн үзэл санааны ачаар тухайн орны багш боловсролын тогтолцоо, бүтэц, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа, тэдгээрийн хэрэгжилтийн үр дүн зэрэгт бий болсон өөрчлөлттэй холбоотой мэдээллийг илрүүлж өгдөг. Жишээлбэл, тогтвортой хөгжлийн шалгуурыг хүн амын ...% цэвэр ундны устай болсон, ТХБ-ын шалгуурыг 5-10 настай хүүхдийн ...% сургуульд элсэн суралцаж байгаа, ТХББ-ын шалгуурыг багш бэлтгэдэг сургуулиудын багш нарын ...% хичээлийнхээ агуулга, аргазүйд ТХББ-ын үзэл санааг тусгасан гэж тус тус тодорхойлж болно.

Улс орон бүрийн бодот ахуй өөр өөр учраас ТХББ-ын шинжүүр нь орон бүрийн хувьд харилцан адилгүй хийгээд бодгаль шинж төрхтэй байх нь ойлгомжтой. Өнөөдөр улс орон бүр ТХББ-ын шинжүүрийг өөрийн орны байгаль-нийгмийн онцлог, уламжлалт соёл ба бүс нутгийн, олон улсын шинэ хандлага хоёрыг нэгдэлд нь авч үзэн, бүх сонирхлын бүлгүүдийн бүтээлч оролцоо, хамтын ажиллагаа бүхий судпан тогтоох эхлээд байна. Улс орон бүхэн уг ажлаа ТХББ-ын шинжүүртэй холбоотой мэдээллийг гарган авч болохуйц, "Бүх нийтийн боловсрол", "Мянганы хөгжлийн зорилт" гэх мэт үүсгэл санаачилгуудтай нягт уялдаатай ажиллах ажиллах замаар гүйцэлдүүлэхийг чухалчилж байна.

ТХББ-ын шшгжүүрийг судлан тогтоохуй

ТХББ-ын шинжүүрийг судлан тогтоохуй нь зорилтоос эхлэх бөгөөд Юу-г шинжих вэ?, Яагаад түүнийг шинжиж байгаа вэ?, Яаж түүнийг шинжих вэ?, түүнийг шинжихүй бидэнд ямар ашиг тусыг авч ирэх вэ?, тэр нь ямар сул талтай байна вэ? зэрэг асуудлыг хамтдаа бүтээлчээр хэлэлцэхүй, хэрэгжүүлэхүй, үр дүнг шинжлэн үнэлэхүйн цогц юм. Учирлах аваас, тухайн шинжүүрийн ашиг тус ба сул тал нь бидэнд түүний тохирч буй эсэхийг тодруулж өгдөг учиртай. Гэхдээ сонирхлын бүлгүүд тухайн шинжүүрийг өөр өөр аргаар тохирох эсэхийг тодруулж болохыг ч энд үгүйсгээгүй билээ. Тухайлбал, тухайн шинжүүр үндэсний ТХБ -ын зорилго, зорилт, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна уу?, уг шинжүүр шинжилгээ үнэлгээний зорилгод хэр сайн тохирч байна?, түүний талаарх баримтыг цуглуулах боломж байна уу?, цуглуулсан баримтаас тэрхүү шинжүүрийг яаж хялбархан ойлгож болох вэ?, тухайн шинжүүрийг харьцуулан жишиж болохуйц

байна уу?, уг шинжүүрийг тодорхойлохын тулд танд ямар бэрхшээл, хэрхэн учрах бол? гэх мэт асуултын тусламжтайгаар тухайн шинжүүрийн таарах эсэхийг ухаарч болно. ТХББ-ын шинжүүрийг судлан тогтоохуйн үндэс нь баримт цуглуулахуй байдаг.

Баримт цуглуулахуй нь ТХББ-ын шинжүүр боловсруулах, түүнийг хөгжүүлэх үйлийн эхлэл болдог. Иймд алив улс орон ТХББ-ын талаарх баримт цуглуулах үйлийг аль болох эртнээс эхлэхийг бодолцох ёстой.

Шинжүүр нэг бүрийг тодорхойлох, хөгжүүлэхийн тулд заавал баримт цуглуулах шаардлагатай байдаг. Цуглуулсан баримт нь тухайн шинжүүрийн хөгжлийн эхлэл, явц, үр дүн гэсэн үе шатыг агуулсан байдгаас гадна тэдгээрийн спиральный дагуух ахиц дэвшлийг шинжлэн үнэлэхийн суурь болж өгдөг. ТХББ -тай холбоотой баримтыг тооны болон чанарын гэсэн 2 өөр төрлийн аргаар (Хүснэгт 2) цуглуулдаг. Өөрөөр хэлбэл, ТХББ -ын баримт нь тооны ба чанарын баримтуудын нэгдэл хэмээн ойлгож болно.

Энэхүү хүснэгтээс баримтыг цуглуулах аргыг сонгон авснаар, та бүхэн тухайн шинжүүр боловсруулах ажлыг төлөвлөх, ажилбар бүрийн эхлэл, явц үр дүнд шинжилгээ үнэлгээ хийх үйл ажиллагаагаа өрнүүлэх боломжтой болдог. Шинжүүр боловсруулахуйг төлөвлөх арга хэрэгсэл буюу ажилбар нь сонирхлын бүлгүүдийн ТХББ-ын үзэл санааг үйл хэрэг болгох төлөвлөгөөг боловсруулах үйл явцыг чиглүүлж өгдөг төдийгүй хэн, хэзээ оролцох шаардлагатайг тодруулахад дэм болдог. Сонирхлын бүлгүүд шинжүүр нэг бүрийг тодруулах ажилбарыг хянан засварлахдаа ямагт :

- Хэдэн удаа баримт цуглуулах вэ?
- Тухайн шинжүүртэй холбоотой ямар баримтууд хэрэгтэй вэ?
- Баримтыг хэнээс болон хаанаас цуглуулах вэ?
- Баримтыг хэрхэн яаж, ямар аргаар цуглуулах вэ?
- Баримтыг хэн хариуцан цуглуулах вэ? зэрэг асуултыг авч үзэж байх ёстой .

Шинжүүрийг боловсруулах үйл нь бүх сонирхлын бүлгүүдэд ТХББ - ыг хөгжүүлэх үйлсэд оролцох боломж олгодог. Шинжүүрийг боловсруулах үйл нь ТХББ -ын талаар тухайн улс оронд нэн чухал ямар үйл явцыг өрнүүлэх вэ? гэдгийг сонирхлын бүлгүүдийн идэвхтэй оролцоотойгоор сайн нягтлахыг шаарддаг. Сонирхлын бүлгүүдийг бид аливаад идэвхтэй оролцуулахын тулд тэд ижил хэмжээний бодтой

дэмжлэг авах хэрэгтэй байдаг. Сонирхлын бүлгүүдийн бүтээлч оролцоо дутсанаас л болж алив үйл ажиллагаа үр дүнгүй шахам болдог хийгээд төгөлдөршлийг бий болгодоггүй гэдгийг бид ямагт анхаарах ёстой. Ийм учраас л бид ТХББ-ын хүрээний алив үйл ажиллагаагаа сонирхлын бүлгүүдэд хөгжлийн үйл явцад бүтээлчээр идэвхтэй оролцохуйц чадавхтай болоход нь бодтой дэм үзүүлэхүйцээр зохион байгуулсан байх хэрэгтэй.

Хүснэгт 2

Тоон болон чанарын баримт цуглуулах арга

Баримт цуглуулах арга	
Тоон баримт	Чанарын баримт
- Эх судлал - Төлөвлөгөө - Тайлан - Хөтөлбөр - Үнэлгээ - Асуулт ба санал асуулга - Суралцагчийн - Төгсөгчдийн - Багш нарын - Удирдлагын - Сонирхлын бүлгийн	- Кейс судалгаа - Агуулгын шинжилгээ дүн - Түшиц хэсэг - Ярилцлага (Хувь хүмүүн /олон нийт) - Ажиглалт - Үйлийн судалгаа - Сургуулийн шалгалт/үзлэг - Түүх ярилцахуй

Оролцсоноороо суралцах үйл явц нь сонирхлын бүлгүүдийн үр дүнтэй, холыг харсан шийдвэр гаргах, үйлийг гүйцэтгэх, санаачлах зэрэгт үзүүлэх бодтой дэмжлэг туслалцааг хангах гол арга зам юм. Чадавхжуулах ажил “өрлийн уулзалт гэх мэт үйл ажиллагаанд оролцуулах замаар сонирхлын бүлгүүд ТХББ-ын шинжүүрийг боловсруулах, үйл ажил болгохуйц чадамжтай болдог.


ТХББ-ын шинжүүрийг судлан тогтоох үйлийн нэг орчил нь өөрийгөө тасралтгүй боловсронгуй болгоход шаардлагатай багц асуулт бүхий 8 үе шатыг агуулдаг (3-р зураг). Шинжүүрийг тасралтгүй боловсронгуй болгох асуултын багц нь түүний үе шат бүрийн явцыг идэвхжүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэх, цаашдын чиг баримжааг зөв оновчлох үүрэг гүйцэтгэдэг.

ТХББ -ын шинжүүрийн бүтэцчилсэн хүрээг тогтоохуйн нэг орчил нь өөртөө

1. ТХББ-ын шинжүүр боловсруулах ажлын хэсэг байгуулах,
2. ТХББ -ын тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтыг оновчлох,
3. Шинжүүрийг тодруулах болон баримт цуглуулах арга зүйг боловсруулах,

4. Шинжүүр болон баримт цуглуулах аргазүйн анхны хувилбарыг өргөн хүрээнд хэлэлцүүлэн, тэдний санал бодлыг тусган сайжруулах,
5. Шинжүүрүүдийг туршин хянаж сайжруулах,
6. Тухайн шинжүүрт чиглэсэн үйлийг хэрэгжүүлэх, ойлгох, зорилгын хүрсэн түвшин ба шинэ тэргүүлэх чиглэлийг үе шаттайгаар тусган сайжруулах,
7. сургуулийн болон үндэсний хэмжээнд хуримтлуулсан туршлага, сургамжаа хэлэлцэн, ахиц дэвшилээ тайлагнах, бүсийн сүлжээн дэх оролцоогоо үргэлжлүүлэх,
8. Тухайн орчлын эхлэл, өрнөл, үр дүн, ахиц дэвшлийн тайлан хэлэлцэх үед гарсан санал, дүгнэлтийг эргэцүүлэн хөгжлийн дараагийн орчлыг эхлүүлэх үйлүүдийг агуулдаг (3-р зураг).

Харин ТХББ -ын шинжүүрийн бүтэцчилсэн хүрээг тогтоохуйн нэг орчлын дагуул асуултын багц нь өөртөө , танай ажлын хэсэгт чадавхаа дээшлүүлэх ямар хэрэгцээ байна вэ?, та бүхэн юуг шинжлэн үнэлэхийг хүсч байна вэ?, та шинжилгээ үнэлгээнийхээ үр дүнг хэнд тайлагнах вэ?, ямар мэдээллээр анги ёстой вэ?, тухайн чиглэлийн мэдээллийг цуглуулж байгаа өөр ямар байгууллага, хүмүүс байна вэ?, яагаад та бүхэн ТХББ-ыг шинжлэн үнэлж байна вэ?, засгийн газар, БСШУЯ, ЮНЕСКО-гийн үндэсний комисс, олон улсын байгууллага, хандивлагчид ямар үүрэг гүйцэтгэж байна вэ? гэх мэтийг өөртөө агуулж болох юм. ТХББ-ын шинжүүрийн бүтэцчилсэн хүрээг тогтоохуйн нэг орчлын дагуул асуултын багц нь бодот ахуй, түүний онцлог болон шинжүүрийн төрөл, шалгуур ба үзүүлэлтээс хамаарч өөр өөр байдаг төдийгүй харилцан адилгүй өөрчилж шинэчлэгддэг.



2-р зураг. ТХББ –ын шинжүүр тогтоохуйн нэг орчлын үе шат ба дагуул асуултууд

ДҮГНЭЛТ

ТХББ ба тогтвортой хөгжихүйц боловсролтой багш гэсэн ойлголтуудыг бодгаль ертөнцийн хандлагын үүднээс авч үзсэнийхээ үндсэн дээр бид дараах дүгнэлтүүдийг хийж байна:

- Багш хүн агуулга, мөн чанар болох хүн, хэлбэр, шинж чанар болох багшийн нэгдэл, түүний үр (1-р зураг).
- Багш хүний бүтэц тогтолцооны (1-р зураг) дагуу багш боловсролыг түүний агуулга ба хэлбэрийн, мөн чанар ба шинж чанарын нэгдэлд нь арга болох багш, билиг болох хүн, арга ба билгийн багцрахуй болох багш хүн гэсэн гурван талаас тус тус авч үздэг хандлагыг ТХХБ, түүнийг эзэмшсэн хүнийг тогтвортой. хөгжихүйц боловсролтой багш гэж үзэж байна.
- Багш хүний ахуй нь багш ба хүн ахуйн, суралцагч хүмүүний ахуй нь суралцагч ба хүншигч ахуйн нэгдэл, Арга болохынхоо хувьд

багш бо суралцагч ахуй нь харгалзан, хүн ба хүншигч ахуйн эрч бөгөөд хөдөлгөгч хүч болж байдаг. Харин хүн ба хүншигч ахуй нь харгалзан багш ба суралцагч ахуйн мөн чанар юм.

- Багш хүний бүтэц тогтолцоо (1-р зураг) нь ТХББ-ын, түүний дүр төрх буюу агуулга, аргазүйн мөн чанар буюу илрэл болно.
- "Тогтвортой" болон "хөгжихүйц" гэсэн тодотголууд нь харгалзан ТХББ –ын агуулгыг болон аргазүйг харгалзан илэрхийлдэг байна.
- Багш хүний бүтэц тогтолцоо бүхий агуулгатай, харилцахуй, суралцаж хүншихүй болон үйлийн явцад суралцахуйн цогц болох аргазүйтэй багш боловсролыг ТХХБ гэнэ.
- ТХББ –ын агуулга, түүний дүр болох хөтөлбөр болон аргазүй нь бодот ахуй (байгаль-нийгэм-соёл-цаг хугацаа буюу хүншигч ахуй), хүмүүний бодгаль ахуй, багш ахуй, суралцагч ахуй дөрвийн багцрахуйтай хийгээд хүн болохуй ба багш болохуйн нэгдэлтэй харилцан

нөхцөлдсөн байдаг. »

- ТХХБ нь бодот буюу хүншигч ахуйн дүр, илрэл, үзэгдэл болох соёл лугаа бодгаль ахуй болно.
- ТХББ нь тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн мөн чанар хийгээд илрэл юм.
- Суралцагч ахуй нь багш ахуйн мөн чанар, агуулга, төрх юм. Иймд багшлахуйн мөн чанар нь хүмүүнийг суралцагч ахуйтай болгох явдал гэж ойлгож болно. Тогтвортой хөгжихүйц боловсролтой багш бусдад тогтвортой хөгжихүйц боловсрол эзэмшүүлдэг шиг суралцагч ахуйтай хүн л бусдыг суралцагч ахуйтай болгож чаддаг. Энэ нь тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн үндсэн шинж төрхийн нэг нь суралцагч ахуйтай болсон байдал болохыг хэлж буй юм.
- Багш ахуйн мөн чанар нь хүн ахуй буюу хүмүүний сэтгэл орон тул багшлахуйн мөн чанар буюу үндэс нь хүн ахуй буюу сэтгэлийн орон гэж гарч буй юм.
- Хүншигч ахуй нь хүн, багш, суралцагч ахуйн мөн чанар төдийгүй илрэл.
- Хүн болохуй, хүн, богш, суралцагч зэрэг ахуйтай болохуй нь хүншигч ахуйн үзэгдэл тул тус бүрийн нь ертөнцийн зураг хүншигч ахуйн ертөнцийн зураг лугаа адил байдаг.
- ТХББ -ыг илрүүлэгч, үйл хэрэг болгон хөгжүүлэгч багш хүнийг тогтвортой хөгжихүйц боловсролтой багш хэмээдэг.
- ТХББ -ын тэргүүлэх чиглэл нь түүний талаарх үзэл санааг түгээн дэлгэрүүлэн тогтворшуулах, сонирхлын бүлгүүдийн бүтээлч оролцоо, хамтын ажиллагааны үндсэн дээр бүтэц тогтолцоо, мөн чанар ба шинж чанарыг оновчлох, агуулга ба аргазүйд тавигдах үндсэн шаардлагуудыг тодорхойлох, үндэсний болон сургуулийн хэмжээний бодлого, чиглэл боловсруулах, хэрэгжүүлэх орчин бүрдүүлэх, хүний хүчин зүйлийн чадавхыг дээшлүүлэх, сургалтын хөтөлбөр, аргазүй, үнэлгээг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, шинжүүрийн бод ахуйг судлан тогтоох, түүнийхээ үндсэн дээр хэрэгжилтийн явц, үр дүнг шинжлэн үнэлж, эргэцүүлж, дахин үзэл санаанаас эхлэн, бүгдийг сайжруулах зэрэг юм.
- ТХББ-ын хүрээний сургалт-судалгааны үйл ажиллагаа, үйл бүр хийсвэр ба бодтой талуудыг нэгдэлд нь авч үзэхүйцээр төлөвлөгдөн хэрэгжих ёстой. Жишээлбэл, ТХББ-ын хүрээн дэх аливааг судалгаа шинжилгээний үйл ажиллагааг индукцийн болон дедукцийн аргыг нэгдэлд нь авч үзэн, төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай.
- ТХББ-ын шинжүүрийн бод ахуйг судлан тогтоох замаар түүний дүр төрхийг, тэргүүлэх чиглэлийг, зорилгыг, зорилтыг тус тус нарийвчлан тодорхойлж болдог (2-р зураг).
- Мөн ТХББ -ын дүр төрх, тэргүүлэх чиглэл, зорилго, зорилтоос түүний шинжүүрийн бод ахуйг тодруулж болдог.
- Тэргүүлэх чиглэлийн дүр нь зорилго, зорилгын дүр нь зорилт, зорилтын дүр нь шинжүүр, шинжүүрийн дүр нь шалгуур юм. Өөрөөр хэлбэл, зорилгын төрх нь тэргүүлэх чиглэл, зорилтын төрх нь шинжүүр, шалгуурын төрх нь шинжүүр гэж үзэж болно.
- Шинжүүрийн нь бод ахуйд ТХББ -ын санаа агуулагдсан буюу үйлдэгдсэн байдаг.
- ТХББ -ын шинжүүрийн бод ахуйг судлан тогтоох үйл явц нь тодорхой бүтэц бүхий орчилтой, дэлгэмэл спиралийн дагуу тасралтгүй дээшлэн дэвших үйл ажиллагааны багцрахуй юм (3-р зураг).
- Багш хүний бүтэц тогтолцооны (1-р зураг) агуулга ба хэлбэр, мөн чанар ба шинж чанар, төрх ба дүр талуудын нийцэл, тохироо нь ТХББ-ын болон тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн, түүний агуулгын ба аргазүйн чанарын үзүүлэлтийн (шинжүүрийн) гэх мэт хэд хэдэн бод ахуйг бүрдүүлдэг.
- ТХББ-ын болон тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн аргазүйн чанарын үзүүлэлтийн (шинжүүрийн) бод ахуйн үндэс нь суралцаж хүншихүйд сурахуй болно.
- ТХББ-ын сургалтын хөтөлбөрийн чанарын буюу үзүүлэлтийн бод ахуй нь түүний хүншигч, хүн, багш, суралцагч ахуй тус бүртэй ба суралцаж хүнших аргазүйтэй тохирсон байдал бол, сургалтын хөтөлбөрийн тооны буюу шалгуурын бод ахуй нь түүний хүншигч, хүн, багш, суралцагч ахуй тус бүрийг болон суралцаж, хүнших аргазүйг тусгасан байдлаар тус тус илэрхийлэгддэг байна.
- ТХ-ийн, ТХБ-ын, ТХББ-ын үзэл санааг оновчлох, түгээн дэлгэрүүлэн тогтворшуулах, түүнийг үйл хэрэг болгох, шинжүүрийн бод ахуйг судлан тогтоох, үр дүнг шинжлэн үнэлэх, цаашид тасралтгүй сайжруулан хөгжүүлэх үйл зэрэг ажиллагааны "цөм" нь тогтвортой хөгжихүйц боловсролтой багшийн багштай болох асуудал болно.

Лавай. 2010. №5